

2025 ОНЫ 5 ДУГААР САР

УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ЦАХИМ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын хувьд 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн Улс төрийн намын тухай хуулийг 18 жилийн дараа бүхэлд нь шинэчлэн баталж, улс төрийн намыг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, санхүүжилт үйл ажиллагаа нь ил тод, хяналттай, хариуцлагатай, Үндсэн хуульт ардчиллын чухал институци, бодлогын нам болон хөгжиж, бэхжих эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах, улс төрийн намын санхүүжилтийг хянах гол үүргийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) хүлээж буй юм. Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд СЕХ 2025 онд Нээлттэй засгийн түншлэл (НЗТ)-ийн сорилтод нэгдэн улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим систем нэвтрүүлэх амлалт хүлээн ажиллаж эхлээд байна. Энэхүү ажлыг санаачилснаар Монгол Улс НЗТ-ээс 2024 онд гишүүн орнууддаа хандан нэгдэхийг уриалж эхлүүлсэн Нээлттэй засгийн сорилт буюу төрийн хариуцлага, ил тод байдал, авлигын эсрэг далайцтай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх санаачилгад Азийн орнууддаа түүчээлэн нэгдсэн анхны улс болсон юм.

Нээлттэй засгийн сорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 4-р сарын 8,9-ний өдрүүдэд

“Улс төрийн намын санхүүжилтийн тайлангийн цахим систем хөгжүүлэх нь олон улсын туршлага, хэрэгцээ шаардлага” семинарыг СЕХ-оос Нээлттэй Нийгэм Форум, Транспэрэнси Интернэшнл, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагатай хамтран зохион байгуулав. Улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн хяналтад оруулахад технологийн шийдлийг ашиглах, цахим систем хөгжүүлэхэд олон улсын туршлага судлах, мэдээлэл солилцох зорилготой уг хуралд хамтран зохион байгуулагч олон улсын байгууллагуудаас гадна Сонгуулийн тогтолцооны олон улсын сан (IFES), Армени улсын Авлигаас сэргийлэх комисс, Английн Бристолийн Их Сургууль, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөх болон Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, “Бодлогод залуусын хяналт” төрийн бус байгууллага, Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл 40 гаруй хүн танхимаар, мөн 30 гаруй хүн цахимаар оролцлоо.

Семинарыг нээж Сонгуулийн тогтолцооны олон улсын сангийн Европ дахь захирал, улс төрийн санхүүжилтийн асуудал хариуцсан ахлах судлаач доктор Магнус Оман илтгэл тавилаа.

МАГНУС ОМАН: УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ЦАХИМААР ИЛ ТОД БОЛГОЖ БУЙ ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН ТУРШЛАГА

Улс төрийн намууд болон улстөрчид улс төр, сонгуультай холбоотойгоор мөнгийг хэрхэн босгож, зарцуулж байгааг ил тод болгох нь авлигыг багасгах, улс төрийн тэгш өрсөлдөөний

орчныг бүрдүүлэх, ардчилалд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой.

Өнгөрсөн долоо хоногийн байдлаар дэлхийн улс орнуудын 82 орчим хувьд улс төрийн намууд

тогтмол санхүүгийн тайлан гаргадаг байхын зэрэгцээ сонгуулийн зардлын тайлан мөн шаарддаг байна. Эдгээрийн олонх нь тайланг цаасаар авч байгаа хэдий ч цахим систем ашиглаж байгаа улс орнуудын тоо нэмэгдсээр байна.

Зарим оронд тайлангийн мэдээллээс зөвхөн товчлон Засгийн газрын албан ёсны сэтгүүл

ТАЙЛАГНАЛТ

Улс төрийн санхүүжилтийн дижитал платформын эхний алхам бол мэдээлэл оруулах үе шат, өөрөөр хэлбэл улс төрийн намууд, нэр дэвшигчид, мөн зарим оронд бусад этгээдүүд (жишээлбэл: Канадад гуравдагч этгээд санхүүжилтийн тайлан, эсвэл Босни Герцеговинад улс төрийн намуудад зар сурталчилгаа зарж борлуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагууд) санхүүгийн тайлангаа хэрхэн гаргаж өгөх тухай асуудал юм.

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Санхүүгийн тайланг цаасаар өгсөн ч хяналт шинжилгээ ба мэдээлэл нийтлэх үйл ажиллагаа нь цахим байх боломжтой. Цахим мэдээллийн санд өгөгдлийг гараар оруулах боломжтой. Жишээ нь, үүнийг Афганистан Улсад 2009 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хийж байсан. Гэвч маш их цаг шаардах тул анхнаасаа цахимаар тайлан авах нь үр дүнтэй.

Улс төрийн намууд нягтлан бодох бүртгэлээ компьютер ашиглан хийх тул цахим хэлбэрээр тайлагнахад төдийлөн хүндрэлтэй биш. Харин нэр дэвшигчдийн хувьд цахимаар тайлан гаргахад зарим талаар хүндрэлтэй байж болно.

Улс төрийн нам, нэр дэвшигчид санхүүгийн мэдээллээ цахимаар өгөх хэлбэрүүдийг авч үзвэл янз бүрийн хувилбар ажиглагдаж байна. Жишээ нь, Латви Улсын Авлигатай тэмцэх газар буюу KNAV тодорхой мэдээллийг Word-р хүлээн авах системтэй.

Зарим улс оронд намуудыг Excel хэлбэрийн хүснэгт ашиглан санхүүгийн тайлан гаргахыг шаарддаг. Тайланг хяналтын байгууллагад цахим шуудангаар илгээдэг. (Жишээ нь: Болгар, Итали, Косово) Эдгээр хүснэгтээс

эсвэл үндэсний сонин хэвлэлд нийтэлдэг. Гэвч бидний амьдарч буй дижитал эрин үед энэ нь хангалтгүй бөгөөд ил тод байдалд хүрэх зорилгыг хангаж чадахгүй юм.

Улс төрийн санхүүжилтийн дижитал платформын үндсэн гурван бүрэлдэхүүн хэсэг нь **Тайлагналт, дүн шинжилгээ, мэдээлэл нийтлэх** юм.

өгөгдлийг мэдээллийн санд шилжүүлэх систем шаардлагатай болно.

Түүнчлэн хэрэглэгч зөвхөн өгөгдөл оруулах хэсэгт өөрчлөлт хийх боломжтой байлгахын тулд хүснэгтийн бусад нүдийг түгжих шаардлагатай. Зарим байгууллагууд Excel маягтаа түгжээгүйгээс үүдэн бэрхшээлтэй тулгарсан байдаг. Франц, Их Британи зэрэг улсуудад ийм явдал гарч байв.

Цөөн хэдэн орон PDF маягт ашигладаг. Энэ төрлийн баримт нь өгөгдөл оруулахад зориулагдсан бөгөөд бусад хэсэг нь түгжигдсэн байдаг.

Ийм маягтаас өгөгдлийг мэдээллийн санд шилжүүлэхэд бага зэрэг төвөгтэй байж болох ч боломжтой юм. Ийм баримтыг ашигладаг орнууд: Бельги, Канад, Өмнөд Африк (жишээлбэл хандивлагчийн бүртгэлд).

Зарим тохиолдолд хосолсон хэлбэр ашиглана. Жишээ нь, Филиппинд улс төрийн намууд PDF болон Excel маягтыг USB диск дээр мөн цаасан хэлбэрээр зэрэг өгөх шаардлагатай байдаг.

Зарим оронд хэрэглэсээр байгаа хуучны нэг арга бол тусгай зориулалтын програм хангамж ашиглах явдал юм. Энэ нь санхүүгийн бүртгэлээс эхлээд тайлан гаргахад жигд стандарт хангагдах давуу талтай. Сул тал нь программ шинэчлэхэд удаан, тухайн хэрэглэгчийн компьютерт суулгах шаардлагатай. Жишээ нь, АНУ-ын FEC байгууллага "FECFile" ашигладаг, Канадын Сонгуулийн газар "Electronic Financial Return" системтэй. Өмнөд Солонгос ч мөн ижил системтэй байсан (хамгийн сүүлийн үеийн мэдээлэл дутмаг).

Хамгийн өргөн хэрэглэгдэж буй арга бол

онлайн өгөгдөл оруулах систем юм. Нам эсвэл нэр дэвшигч хяналтын байгууллагын вэбсайт руу орж, мэдээлэл хэрхэн байршуулах зааврыг даган өгөгдлөө оруулдаг. Ийм системийг ашигладаг орнуудыг дурдвал Их Британи, Армени, Франц, Исланд, Швед, Латви гэх мэт улсууд байна.

Ийм арга ашиглахад анхаарах зүйлс: Системд зөвшөөрөл бүхий этгээд мэдээлэл оруулж байгаа эсэхийг баталгаажуулах нэвтрэх

систем байх шаардлагатай. Өгөгдөл бүрэн хадгалагдаж байгаа эсэхийг хянах, системийг хэрэглэгчдэд ойлгомжтой, ашиглахад хялбар байлгах, хэрэглэгчдэд зориулсан зааварчилгаа, сургалт тогтмол явуулах хэрэгтэй.

Системийг хөгжүүлэхэд оролцогч талуудтай хамтран ажиллах нь чухал юм. Ингэснээр системд хэрэглэгчдийн дэмжлэгийг авах, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоотой нийцлийг хангахад дөхөмтэй болно.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цахим системийн хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг болох дүн шинжилгээ нь өгөгдөлд үндэслэн санхүүгийн тайлан нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах зорилготой. Зарим тохиолдолд энэ ажиллагаа нь зөрчлийг шууд илрүүлнэ (жишээ нь: хуулиар тогтоосон дээд хэмжээнээс давсан хандив эсвэл зардал гэх мэт). Харин зарим тохиолдолд гүнзгийрүүлсэн хяналт шалгалт хийх шаардлага байгаа хэсгүүдийг тодруулж “анхааруулах дохио” өгөх үүрэг гүйцэтгэнэ.

Цахим шинжилгээний хэрэгслүүд нь гар ажиллагааг бүрэн хална гэсэн үг биш, харин тэдгээрийг илүү хялбар, үр дүнтэй болгох боломжийг олгодог.

Мөн улс төрийн санхүүжилтийн өгөгдлийг шинжлэх үед хувийн нууцыг хамгаалах асуудал үүсэж болно. Тодорхой этгээд хүний хувийн мэдээлэлд нэвтрэх боломж өгөлгүй өгөгдлийн баазуудын хооронд уялдааг хангаж мэдээллийг харьцуулан нягтлах боломжтой байдлаар системийг хөгжүүлэх бололцоотой.

Бусад өгөгдлийн баазуудтай харьцуулан шинжилгээ хийх нь маш үр дүнтэй бөгөөд бага хүчин чармайлтаар өндөр үр дүн гаргах боломжтой. Жишээлбэл, Монгол Улсын хууль тогтоомжид хандив авахыг хориглосон этгээд нэлээд олон байдаг. Гар аргаар ийм зүйлийг шалгах нь маш төвөгтэй байх байсан.

Шинжилгээ хийхэд ашиглаж болох үндсэн өгөгдлийн баазууд:

- Татварын бүртгэл — Орлогоор нотлогдохгүй хандивыг илрүүлнэ.
- Иргэний бүртгэл — Хандив зөвхөн насанд хүрсэн, Монгол Улсын иргэн этгээдээс ирсэн эсэхийг шалгана.
- Хуулийн этгээдийн бүртгэл — Хандив өгч буй хуулийн этгээд нь Монгол Улсад бүртгэлтэй, дампуураагүй, үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг шалгана.
- ТББ-ын бүртгэл — Хандив өгөх эрхгүй байгууллагууд (төрийн бус байгууллага, шашны байгууллага, үйлдвэрчний эвлэл гэх мэт)-ыг илрүүлнэ.
- Банкны мэдээлэл — Төсвийн хөрөнгийн зарцуулалт, хандивын орлого гэх мэт мэдээллийг баталгаажуулахад ашиглаж болно.

Эдгээр бүх өгөгдлийг автоматжуулсан хэлбэрээр шалгах боломжтой болсноор шалгалтын үр нөлөө хэд дахин нэмэгдэнэ.

Анхаарах гол зүйлс:

- Хэн ямар мэдээллийг шинжилж, хяналт тавих вэ?
- Хувийн нууцыг хэрхэн хамгаалах вэ?
- Аль төрлийн зөрчлийг автоматаар илрүүлж болох вэ?
- Аль тохиолдолд гар шалгалт шаардлагатай вэ?

МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЛЭХ

Цахим системийн гурав дахь бүрэлдэхүүн хэсэг бол нийтлэх буюу улс төрийн санхүүжилтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгох үйл явц юм. Энэ бол хамгийн чухал бүрэлдэхүүн нь бөгөөд үүнийг хангалтгүй хийвэл цахим систем хөгжүүлэх нь ач холбогдолгүй болно.

Зарим оронд тайлангийн зөвхөн товч мэдээллийг албан ёсны сэтгүүл эсвэл сонинд нийтэлдэг. Гэвч өнөө цагт энэ нь хангалтгүй – интернэт орчинд иргэд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй, машинд уншигддаг боловсруулж болохуйц, хялбар хайж болох мэдээлэл хүлээн шаарддаг болоод байна.

Улс төрийн санхүүжилтийн мэдээллийг ашиглах янз бүрийн хэрэглэгчид ямар хэрэгцээ, сонирхолтой байж болохыг анхааралтай авч үзэхийг зөвлөж байна. Жишээлбэл, сэтгүүлчид ихэвчлэн хурдан, хялбархан ашиглах боломжтой, нэмэлт нарийн шинжилгээ шаарддаггүй форматаар мэдээлэл авах сонирхолтой байдаг – ийм тохиолдолд инфографик тэдний хэрэгцээнд нийцэх боломжтой. Харин судлаач, эрдэмтэд ихэнхдээ цаашид шинжлэх боломжтой анхдагч, боловсруулаагүй мэдээллийг илүүд үздэг – тэдний хувьд мэдээлэл хурдан бэлэн байх нь төдийлөн чухал биш байдаг.

Цахим нийтлэлийн гол зорилго бол ард иргэдийн хяналт тавих боломжийг хангах юм. Хэрвээ мэдээлэл олон нийтэд ойлгомжтой, хайхад хялбар, нээлттэй хэлбэрээр хүргэгдэхгүй бол, ил тод байдлын ач холбогдол огтхон ч биелэхгүй.

Ерөнхийдөө, хайлт хийх боломжтой ба мэдээллийг татаж авах боломжтой өгөгдлийн сан нь хамгийн оновчтой шийдлүүдийн нэг гэж үзэж болно. Хайлтын боломжийн тухайд нэгэн нийтлэг зарчим бол – систем нь хэрэглэгчдэд тодорхой нэг хүн эсвэл байгууллага аль нэг улс төрийн намд хэзээ хандив өгсөн эсэхийг хялбархан олж мэдэх боломжийг олгох ёстой.

Дээр дурдсанчлан, мэдээлэл цаашид шинжилгээ хийх боломжтой форматаар

татаж авах боломжтой байх нь туйлын чухал. CSV (comma separated value) буюу таслалаар тусгаарласан утгатай файл нь өргөн хэрэглэгддэг ч санхүүгийн мэдээлэлд таслал хэрэглэгддэг тохиолдолд асуудал үүсэж болдог – ийм нөхцөлд TSV буюу таб тэмдэгтээр тусгаарласан утгатай файл илүү тохиромжтой байж болно.

Анхаарах гол зүйлс:

- Өгөгдлийн форматыг тодорхойлох: Зөвхөн PDF эсвэл зураг хэлбэрээр биш, машинд уншигдах форматаар (CSV, Excel гэх мэтээр) нийтлэх шаардлагатай.
- Хайлт хийх боломж: Иргэд тодорхой нэр, нам, сонгуулийн үе гэх мэтээр шүүж харах боломжтой байх ёстой.
- Шүүлт, дүн шинжилгээ хийх функцүүд: Нийт хандивын дүн, зарцуулалтын бүтэц, хандивлагчдын тоо гэх мэт тоон мэдээллийг автомат тайлан хэлбэрээр харуулах.
- *Ил тод байдлыг хувийн мэдээлэл хамгаалах зарчимтай:* Нэр, хаяг, хувийн мэдээлэл зэргийг хамгаалах шаардлагатай тохиолдолд нууцлалын зохистой хязгаарлалт тавих.
- Өгөгдлийн бүрэн байдал: Тайлангийн мэдээлэл бүрэн, цаг хугацаанд нь шинэчлэгдсэн, системтэй байх шаардлагатай.

Жишээ нь: Их Британи, Канад зэрэг орнууд хандив, зардлын мэдээллийг онлайнаар бүрэн үзэх боломжтой системтэй.

- Зарим орны системүүд нь иргэдэд интерактив хяналт тавих хэрэгсэл (график, диаграм, харьцуулалт) санал болгодог.

Монголд ч ийм төрлийн системийг нэвтрүүлэх боломжтой бөгөөд иргэдийн оролцоо, авлигагүй улс төрийг дэмжих томоохон алхам болно.

Эцэст нь дүгнэн хэлэхэд улс төрийн санхүүжилтийн ил тод байдлыг хангах цахим систем нь ардчилалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, авлигыг бууруулах, улс төрийн өрсөлдөөний шударга байдлыг хангах чухал хэрэгсэл юм. Цахим платформыг хөгжүүлэхдээ:

- Оролцогч талуудтай зөвлөлдөх
- Хэрэглэгчдэд ээлтэй, ойлгомжтой систем боловсруулах
- Нууцлал, аюулгүй байдлыг хангах
- Боловсон хүчний чадавх, сургалтыг байнга дэмжих шаардлагатай.

УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ЦАХИМ СИСТЕМ БҮХИЙ ЛАТВИ, АРМЕНИ, АНГЛИЙН МЭРГЭЖИЛТЭН СУДЛААЧИД ТУРШЛАГАА ТАНИЛЦУУЛАВ

Улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах, цахим шийдлийн талаар Латви, Армени зэрэг олон улсын туршлагаас мэдээлэл солилцсон бөгөөд Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын улс төрийн намын үндсэн багийн гишүүн, Латви улсын парламентын гишүүн асан Лолита Сиганэ улс төрийн намын санхүүжилтийг тайлагнах цахим шийдлийн туршлагын талаар мэдээлэл өгч, оролцогчдын асуултад хариуллаа. Латви Улсад намын санхүүжилтийг тайлагнахад EDIS цахим систем ашигладаг. Тус систем нь төрийн байгууллагаас намуудтай харилцах гүүр болохоос гадна техникийн түвшний шийдэл нь улстөржих эрсдэлээс сэргийлж, оролцогчдод тохирох нэг хэмжээс ашиглахаас гадна өгөгдлийг хялбар боловсруулж, хянах боломжтой гэдгийг онцлов.

Санхүүгийн тайлангийн өгөгдөл оруулах систем нь мөнгөн, мөнгөн бус, бусад хандивыг оруулсан даруйд нийтэд мэдээлэх боломжтойгоос гадна орлого, зарлага нь автоматаар бүртгэгдэж, нэгтгэгддэг. Төрөөс олгосон санхүүжилтийг хэрхэн ашиглаж буйг системээр олон нийт хянах боломжтойг танилцууллаа. Тайлангийн систем дэх мэдээлэл нийтэд нээлттэй бөгөөд мэдээлэл авч дүн шинжилгээ хийх, хандивлагч өөрийн хандиваа хянах боломжтой аж. Тухайлбал, хувийн эх үүсвэрээс орж ирсэн хандивыг бүтцийн хувьд хэмжээ, давтамж, идэвхтэй дэмжигч, тэдний ажилладаг салбар зэрэг үзүүлэлтээр тоймлодог. Мөн улс төрийн нам, хандивын ангилал, хандивлагчийн мэдээлэл, цаг хугацаа

зэрэг сонголтоор хайлт хийх мэдээллийн сан бүрдүүлснийг танилцууллаа. Цахим системээс гадна тайлангийн аппликэйшн нэвтрүүлсэн нь өргөн хэрэглээтэй байдгийг дурдсан юм.

Хиймэл оюун ухааны тусламжтайгаар намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, хянах боломж, сорилтын талаар Английн Бристолийн Их сургуулийн Улс төрийн тэнхимийн профессор, доктор Сэм Пауэр илтгэл хэлэлцүүлсэн. Сонгууль эрхэлсэн байгууллагын нөөц, сонгууль зохион байгуулах цаг хугацаа хязгаарлагдмал тул хиймэл оюун ухаан ашиглах шаардлагатайг тэр бээр дурдаад зөв ашиглаж чадвал олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтойг онцолсон юм. Хиймэл оюун ухаан нь их хэмжээний өгөгдлийг богино хугацаанд хямд өртгөөр боловсруулах боломжтой. Англи Улсад сонгуулийн төв байгууллагад ирүүлсэн нэхэмжлэлүүдийн шинжилгээнд суурилан хиймэл оюун ухааны арга хэрэгсэл хөгжүүлж байгаа бөгөөд PDF файлаар дүр таних системд оруулж, ангилснаар хиймэл оюун ухаан ашиглах өгөгдлийн сан бүрдүүлсэн байна. Хиймэл оюун ухааныг нэвтрүүлснээр хяналт тавих, авлигаас сэргийлэх, авлигын эсрэг “Улаан туг” систем ашиглах боломж бүрдэхээс гадна нягтлан бодох туршлагыг стандартжуулах, мэдээлэл ил тод нээлттэй болох зэрэг ач холбогдол байгааг нөгөө талаар хуулийн орчин бүрдүүлэх, алба хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, итгэлцлийг бүрдүүлэх зэрэг сорилт тулгардаг зэргийг дурдсан.

БҮЛГҮҮД УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОВ

Оролцогчид семинарын хоёр дахь өдөр хэрэглэгчдийн бүлэгт хуваагдаж цахим системийн хэрэгцээг тодорхойлон ажиллаж, санхүүжилтээ тайлагнах улс төрийн намуудын төлөөлөл системд хуульд заасан цаг хугацааг хуваарь болгон оруулах, хувь хүний нууцлал, аюулгүй байдлыг хангах болон хандивлагчийн лавлагаа, мэдээллийг татаж авах, хуульд заасан шаардлага хангасан эсэхийг шалгах шийдэлтэй байх, тайланг олон байгууллага руу явуулдаг байдлыг хялбарчилж төрийн байгууллагуудын уялдааг хангах хэрэгцээг онцолсон.

Системээс мэдээлэл авах хэрэглэгчдийн төлөөлөл болох иргэний нийгмийн байгууллагууд хандивлагчдын мэдээллийг компани, хэр хэмжээний хандивыг хэдэн намд өгсөн, эзэмшигч нь хэн зэрэг олон төрлөөр боловсруулж, ангилсан мэдээлэл харах, тайланг

бүлэглэсэн байдлаар болон ерөнхийгөөр татаж авах боломжтой байх шаардлагатайг илэрхийллээ. Мөн төрийн санхүүжилт зарлах, авах, зарцуулах зэрэг бүх үйл явцын мэдээлэл, намуудын хөрөнгө, хандивлагчийн хамаарал бүхий компаниудыг ангилсан байдлаар харах боломжийг бүрдүүлэх хэрэгцээ тодорхойлсон.

Семинарт оролцогчид цахим системийн шаардлагыг тодорхойлохдоо хандивлагчийн мэдээллийг оруулахад голчлон саналаа хэлсэн. Тиймээс цахим системийн эхний ээлжийн хөгжүүлэлт хандивт түлхүү анхаарахыг семинар зохион байгуулагчид зөвлөсөн бөгөөд цахим системийн шаардлага тодорхойлох, ажлын даалгавар бэлтгэх, хөгжүүлэхэд хамтран ажиллахыг хэрэглэгч болох улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудаас хүссэн болно.

УЛС ТӨРИЙН НАМУУДААС ГАРГАСАН САНАЛ:

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Хандивтай холбоотой үзүүлэлтүүд/өгөгдөл: - Хандивын хэмжээ - Хандивын зарцуулалт - Хандивын ангилал - Хандив өгсөн ААН хувь хүний мэдээлэл - Хандивын огноо, хэмжээ зэрэг мэдээллийг он сар өдрөөр шүүлт хийх - Ихээс бага, багаас ихийг эрэмбэлж үзэх боломж - Хандивыг байгууллага регистрийн дугаараар, иргэний бүртгэлийн дугаараар	- Намын санхүүгийн зарцуулалтад хяналт тавих - Санхүүгийн хандивын мэдээллийг харж хуульд нийцсэн буй эсэхийг харах
Сар бүр орлогыг тухай бүр бүртгэж оруулах боломж нээх Сар бүрийн хандив, орлого, зардал мэдээлэл ил тод нийтлэх	Систем гүйцэд хөгжих хүртэл
Хуулийн этгээд хандив өгөх үед хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг автоматаар шалгах	Хуулиар тогтоосон хандивын хязгаар хэтрэхээс сэргийлэх Зарим хуулийн этгээдийн мэдээлэл дутуу орсноос хууль зөрчсөн хандив хүлээж авч асуудал үүсэх
Хандив өгөхөд хувийн нууцлалтай зарим мэдээлэл тухайн хүнээс шаардахгүй тэр талаар системд оруулахаас татгалзах Зөвхөн регистрийн дугаарыг оруулах. Төрд байгаа гэрийн хаяг, ургийн овог гэх мэт мэдээлэл нэхдэггүй байх Регистрийн дугаараа оруулахад тухайн хүний хандивыг өмнөх өгсөн мэдээлэл шүүж гаргаад хандив хэтэрсэн үгүйг гаргадаг байх	Хуулиар хамгаалсан хүний хувийн мэдээлэл

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Намын дансны хуулгыг (форматын дагуу) тодорхой засвар оруулаад экселээс импорт хийж оруулахад бүх мэдээллийг боловсруулдаг байх. Хандив, татвар дээр дата боловсруулж, алдааг заадаг шүүлтүүрүүд үүсгэх.	Хуулгыг импорт хийсний дараа
Санхүүгийн тайлан гаргах боломжтой байх	Хүснэгтэн мэдээллийг (өгөгдлийг) зөөвөрлөж оруулахад шууд программ дээр уншдаг байх (программын тохиргоотой байх) Бүх намууд нэгдсэн нэг стандарт дагах боломж бүрдэнэ
Хандив хүлээн авахад хоорондоо хамаарал бүхий компаниудад давхардсан хандивыг шүүж ялгадаг байх	
Тайлан өгөхөд регистр нэгдсэн сангаас татдаг болох Татвар болон санхүү, нийгмийн даатгалын мэдээллийг өөр дээрээ тухайн сайтаас татаж авч тухайн намын тайлангуудыг харж үзэх боломжтой байх	Бүх тайлангуудаа тусдаа тайлагнаад дараа нь дахин татаж авч хэд хэдэн хувь хэвлэж тал талд өгдөг нь цагийн хувьд мөн санхүүгийн хувьд ч гарзтай
Төлбөрийг бүртгэх болон өөрийн программд бүртгэх үед лавлагаа мэдээллийг нэгдсэн байдлаар татаж авах боломжийг бүрдүүлэх, толгой компани өр төлбөр,бусад хуулийн шаардлага программтай холбогдох боломжтой байх.	Өртэй ААН-ийг гүйлгээ хийхээс өмнө шалгах боломжтой байх. (ХУР) систем төлбөртэй тул тухайн системээс шууд бусаар татаж бэлтгэх.
Их мэдээллийг оруулах, шалгах боломжийг илүү хөнгөвчлөх байдлаар программыг хөгжүүлэх.	100,000-300,000 дата түүнээс их мэдээллийг шалгах шаардлага тулгарна. Энэ үед нэг бүрчлэн бүртгэх боломж бага.
Хандивыг бүртгэхээс өмнө болон тухайн үед улс төрийн намын санхүүгийн программ болон бусад программтай хялбар байдлаар холбогдох боломжтой байх.	Ажлын ачааллыг хөнгөвчлөх
Намын хандив, гишүүний татвар, бусад орлого мөн зарлагын бүртгэлийг excel-с шууд татуулж болдог байх	Олон гүйлгээтэй намд тухайн хандивыг нэгбүрчлэн бүртгэх нь их цаг шаардсан асуудал гаргах эрсдэл ихтэй.
Өөрийн намын - Тайлангууд - Санхүүжилтийн дүн - Хандивууд - Орлого - Зарлага зэргийг тодорхой ангилалтайгаар харах боломжтой байх	Намынхаа ерөнхий санхүүгийн мэдээллийг нэгдсэн байдлаар хүссэн цагтаа хардаг бол амар
Урьдчилсан автомат сануулах мессеж- Хуульд заасан хугацаанд ямар мэдээлэл өгөх мэдэгдлийг явуулдаг байх	Заримдаа мэдээгүй, санаагүйгээс болж хуулийн хугацаанаас хоцрох, цаг тулгах асуудлууд гардаг
Тайлангийн маягт заавар тодорхой, ойр ойрхон өөрчлөгдөхгүй тогтмол байх	Хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх
Серверийн хурд, аюулгүй байдал, нууцлал, өргөтгөх боломж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах	Хувь хүний болон бусад мэдээлэлтэй холбоотой айдас байдаг, ажлыг хялбарчлах
Улс төрийн намын өөрийн системийг хөгжүүлэхэд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх	Мэдээлэл цуглуулах үед хамгийн эхний датаг хялбар үнэн зөв бүрдүүлэх нь чухал, ялгаатай байдлаас болж хүндрэл үүсгэхийг багасгах.
Сонгуулийн зардлын мэдээлэлтэй холбох, намаас гадна хувь нэр дэвшигчийн хандивын мэдээллийг бас давхар харуулах боломжтойгоор шийдэх	Мэдээлэл ил тод байх аливаа нөлөөллийг шалгах

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Нэгдсэн мэдээллийг авах боломжийг сайжруулах, төрийн байгууллагын уялдаа холбоо, программ хоорондын нийцлийг сайжруулах мэдээллийн төвлөрсөн функцийг хөгжүүлэх	Тухайн хүний мэдээллийг давхардсан болон цаасан байдлаар авахаас зайлсхийх.
Системд хуулга оруулсны дараа боловсруулалт хийх боломжтой, цаасаар мэдээлэл өгөх шаардлагагүй болгох	

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН САНАЛ:

САНГИЙН ЯАМ

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Улс төрийн намын санхүүгийн тайлангаа хугацаандаа илгээх	Зөвхөн улс төрийн нам биш ААНБ-ууд цагаа тулган гарч болзошгүй эрсдэлийг тооцдоггүй
Тулгаж асуудал гаргахгүй шийдвэрлэхийг хүсэхгүй байх	Асуудлыг сүүлийн мөчид тавьдаг. Ажлын цаг болон сунаж ажиллах систем зөвхөн СЯ-аас хамаарахгүй, хамтрагч байгууллага шийдвэрлэдэг.
Мэдээллийг үнэн зөв бөглөх	Чухал биш гэж үздэг
Холбогдох тайлбар, мэдээллийг оруулах	Мэдээллийн оронд шалгуур copy past хийдэг

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Иргэд, олон нийтэд улс төрчдийн санхүүжилтийг мэдээлдэг цэс үүсгэж улирал тутам оруулах системийг бий болгох	Иргэд, олон нийт мэдээлэлтэй болсноор хөндлөнгөөс хянах боломж бүрдэнэ.
Төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах Төрийн байгууллага Банк бус санхүүгийн байгууллага, арилжааны банкнуудтай уялдаа холбоотой мэдээлэл солилцдог систем бий болгох	Улс төрийн нам бүлгэмүүдийн мэдээллийг жил бүр олон нийтэд тайлагнах боломж бүрдэнэ.
Хандив өгсөн этгээдтэй холбоотой хуулийн хугацаанд захиргааны шийдвэр гаргахгүй байх	

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Хандивын эх сурвалж бүрийг харах боломжтой байх	Хандивыг оруулсан тухай бүр /анхан шатны баримт шаардах
Намын гишүүний татварын хэмжээг нам тус бүрээр жилд оруулсан орлогын хэмжээгээр	
УБЕГ хориглосон этгээдийг шалгах боломж, биш бол гүйлгээг тухай бүр мэдээлэх - гүйлгээнд хийх — нэг дансаар орох	Хориглосон этгээд хандив өгсөн эсэхийг автоматаар шалгах
Хуульд заасан бүх хязгаарлалтыг систем мэдээлдэг байх	СЕХ тайланг хянахад өнгөөр ялгарч харагдах
Төрийн санхүүжилтийг хэрхэн зарцуулах талаар хуульд тусгагдсаны дагуу программын өгөгдлийг нийцүүлэх	Ангилалд нь бүртгэхэд

Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн данс	
Орлогын хэмжээг нэгтгэн үзүүлэх (жилийн эцсээр)	УТНТХ-ийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4 / 2 дахин их
Хөрөнгийн мэдээллийг нэгтгэн харуулах (жилийн эцсээр)	Хуульд заасны дагуу мэдээлэл гаргах
Намуудын салбарын тайланг тусад нь харуулах (Хагас, бүтэн жилээр)	Хуульд хамт ирүүлнэ, мөн түүвэр хяналт хийхэд
Төрийн бусад байгууллагуудын цахим системтэй холбогддог байх	Мэдээлэл солилцох
Намуудын санхүүгийн тайлан, мэдээлэл нэг форматтай байх	Одоогоор өөр өөр программ дээр намууд тус тусдаа ажиллаж байна. Ижил программтай болох
Хуульд заасан хязгаарлалтуудыг хянадаг байх	Хянах ажиллагааг хөнгөвчлөх
Программ нь мэдээлэл хүлээж авахдаа аль болох хүснэгтэн, өгөгдлийн хэлбэрээр мэдээлэл хүлээж авдаг байх	Мэдээлэл нэгтгэхэд хялбар
Намын тайланг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан тоон гарын үсгээр баталгаажуулах	Зарим тохиолдолд эрх бүхий албан тушаалтан баталж ирүүлдэггүй
Улсын бүртгэлийн системээр иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг систем татаж хардаг байх	Хандивлагчийн мэдээлэл үнэн зөв эсэхийг хянах
Хандивлагч иргэн 18 нас хүрсэн эсэх, гадаадын иргэншилтэй эсэхийг иргэний бүртгэл мэдээллээс автоматаар шалгах боломжтой байх	Хориглосон этгээдээс хандив авч байгааг программ илрүүлдэг байх
Хандивлагчийн өгсөн хандивыг нэгтгэж харуулах	Давхардуулж хандив өгсөн эсэхийг хянах
Хандивлагчийн өгсөн хандив хуульд заасан дээд хэмжээнээс хэтэрвэл, хуулиар хориглосон этгээдээс хандив орж ирвэл системээс сануулах дохио өгдөг байх	Хяналтын ажлыг хялбар болгох
Татварын системээс намын мэдээллийг нягтлах	Нам үйл ажиллагаа явуулсан эсэх, дансны мэдээллээ бүрэн мэдээлсэн эсэхийг хянах
Сангийн яамны тайлангийн системээс нам тайлангаа илгээсэн эсэхийг харах	
Намын гишүүний татвар төлсөн гишүүдийг жагсаалтаар харах	Гишүүний татвар төлсөн гишүүдийн тоог тогтоох Гишүүний татвар хуульд заасан хэмжээг зөрчсөн эсэхийг хянах
Гишүүний татвар төлсөн хэмжээг харуулах	
Хуульд заасан хэмжээ хэтэрсэн бол системээс сануулах дохио өгөх	
Нам төрийн санхүүжилт авсан бол санхүүжилтийг харуулах	
Төрийн санхүүжилтийн зарцуулалтыг хуульд заасан байдлаар ангилж харуулах	Төрийн санхүүжилтийн зарцуулалт хуульд заасан хэмжээнд нийцэж байгааг хянах
Төрийн санхүүжилтийн зарцуулалтын дэмжих баримтыг хавсаргаж оруулах	
Мөнгөн бус хандив авсан бол хандивын мэдээлэлтэй цуг дэмжих баримт/гэрээ оруулах	Тайлан хянах явцыг хялбар болгоно
Нам өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар орлого олсон бол орлогын мэдээллийг дэмжих баримттай хамт оруулах	Тайлан хянах явцыг хялбар болгоно
Админ:	
- Дүр	Системийг хөгжүүлэхэд
- Эрхийн тохиргоо	
- Системд болон томьёо, маягт засахад хялбар	
Үйл ажиллагаа зохицуулах:	
- Хамгаалагдсан	
- Useful	
- Дохио мэдэгдэл өгдөг байх	

Хөгжүүлэгч:

Цар хүрээг оновчтой тодорхойлсон байх

- маягт
- томьёо
- үр дүн, тайлан
- файл оруулах, бүртгэл гаргах формат
- процесс
- ямар программ хангамж, кодчилал ашиглах

Ажлын даалгавар нь маш тодорхой, хууль эрх зүй, үйл ажиллагааны уялдаа холбоог бүрэн гаргасан байх шаардлагатай

Ашиглах, хэн юуг, хэзээ хийх, журам, заавар бэлтгэх

Систем хоорондын уялдаа холбоотой байх

Бусад программ хангамж бүгд гаргах боломжтой

Санхүүгийн программтай болгох

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Хандив өгсөн компани/хүнийг нэрээр хайх боломжтой байх	Нам бүрийн хандивыг харах үед
Нийт орлогын дүнг хандивлагчаар харах компани/хувь хүн	Компани эсвэл хувь хүн аль нь их хандивлаж байгааг харах
Нийт хандивын дүнг үзэхэд хандив өгсөн хувь хүн/компани тоо харагдах	Аль намд компани/хүнийг илүү дэмжлэг авч байгааг харах
Улс төрийн намууд нэр дэвшигчдийн ашиг сонирхлын зөрчилтэй салбарыг тодорхойлох боломжтой байх	Сонгогдсоны дараа хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчилтэй хуралд орохыг хориглоно
Намуудын бодлого боловсруулалтыг сайжруулж, чадамж нэмэгдүүлсэн талаар мэдээлэх	Сонгуулийн үеэрх мөрийн хөтөлбөр, амлалтуудын хэрэгжилт биелэлтийн түвшин харахад Бодит байдал дээр биелэгдэх эсэх, сонгогчдын саналыг авахын тулд байгаа талаар судлах
Намууд намын нэр дэвшигчид ирдэг хандив, хандивлагчийн мэдээлэл	Сонгуулийн үеэр зардлын тайланд мониторинг хийхэд санхүүжилтийг харах, иргэдээс бодитой хандив авч байгаа эсэх
Төрийн санхүүжилт	Улсын төсвийг зүйтэй зарцуулсан эсэх, хамтарч хөтөлбөр гаргаж ажиллах
Намуудын хөгжлийн бэрхшээлтэй гишүүдэд зориулсан бодлого, санхүүгийн төлөвлөгөө, зарцуулалтыг дэлгэрэнгүй мэдэх	Биелэлтийг харахад санхүүгийн зарцуулалтыг харах үед Сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгогдох боломж, асуудал байгаа эсэх, дэмжлэг хэр байгаа эсэхийг харах
Залуучууд, эмэгтэйчүүдийн талаарх бодлого, төлөвлөгөө	Төлөвлөгөө хэрэгжилтийг харьцуулах
Нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг харуулах	Санхүүгийн сахилга бат үүсгэх учир
Нэр дэвшигчийн намд өгсөн хандивыг ил тод харуулах	Сонгуулийн зардлын мэдээлэл тусдаа тайланд байгааг нэгтгэх нь цогц хяналт болно
Нам, орон нутаг, иргэн, бизнес, мөн тэдгээрийн байршил, нас, хүйс зэргээр ангилж харах боломжтой байдлаар санхүү хандив, хөрөнгө босголтын мэдээллийг харах, харьцуулж харах	Сонгуулийн үер (real time) Улс төрийн санхүүжилтийн хариуцлага, ил тод байдал, бодлого, шийдвэрийн хяналт мониторинг хийх, цаашид системийн өөрчлөлт хийхэд зориулан анализ хийх

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Нам тус бүрийн санхүүгийн тайлан бүрэн эхээр (эцсийн аудит)	Намын тайланг илгээх Жил бүхийн 5 сард багтаан СЕХ тайланг харах Хэдий хэмжээний мөнгөтэй нам болохыг мэдмээр байна.
Хөрөнгийн мэдээлэл (үл хөдлөх, хөдлөх)	Намын санхүү СЕХ Ямар хөрөнгөтэй үнэлгээ нь ямрыг мэдэхгүй
Хандивын хуулийн этгээдээр (RD)	Мэдээллийг татахад давтагдахгүй дугаар хэрэгтэй
Төрийн санхүүжилтийн зарцуулалт, хэнээр юу хийлгэсэн бэ?	Үр дүнг хэмжих
Нэг нэр дэвшигч хэдэн хувь хүнээс болон компаниас хандив авсан болохыг мэдэх	Сонгуулийн үед болон сонгуулийн дараа Хэр олон хүн эсвэл хэн хэн түүний дэмжиж байгааг мэдэх хэрэгтэй
Хамаарал бүхий компаниуд /охин компани, салбар, ах дүүсийн гэх мэт нийт хэдэн төгрөгийн хандив өгсөн болохыг	Сонгуулийн зар, сурталчилгааны үед хуульд заасан хэмжээг зөрчөөгүй эсэх (шударга өрсөлдөөнийг хангах)
Хандивлагчийн хөрөнгийн эх үүсвэрийг харах	Сонгуулийн зардлын тайлантай танилцах үед Сонгуулийн санхүүжилт нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн эсэхийг харах
Мөнгөн бус хандивыг мөнгөнд шилжүүлсэн дүнг харах	Сонгуулийн санхүүжилтийн тайлангийн үед мөнгөн бус хандив нь хуульд заасан хэмжээнд байгаа эсэхийг харахад хялбар үр дүнтэй.
Ямар компани хэдэн нэр дэвшигчид хандив өгсөн байгааг харах	Сонгуулийн үед болон сонгуулийн дараа парламентад ашиг сонирхлын зөрчлийг хянахад хэрэгтэй
Хандив өгсөн бизнесүүдийг ангилж харах боломжтой мэдээллүүд (анализ хийх боломжтой байх)	Сонгуулийн үед болон сонгуулийн дараа Хэр олон хүн эсвэл хэн хэн түүний дэмжиж байгааг мэдэх хэрэгтэй
Хандивлагчийн хөрөнгийн эх үүсвэрийг харах	Сонгуулийн санхүүжилт нь хууль ёсны эх үүсвэрээс бүрдсэн эсэхийг харах
Мөнгөн бус хандивыг мөнгөнд шилжүүлсэн дүнг харах	Мөнгөн бус хандив нь хуульд заасан хэмжээнд байгаа эсэхийг харахад
Ямар компани хэдэн нэр дэвшигчид хандив өгсөн байгааг харах	Сонгуулийн үед болон сонгуулийн дараа парламентад, мониторинг Ашиг сонирхохын зөрчлийг хянах хэрэгтэй
Хандив өгсөн бизнесүүдийг ангилж харах боломжтой мэдээллүүд (анализ хийх боломжтой байх)	Сонгуулийн сурталчилгааны үер Сонгогчдод мэдээлэл хүргэх

СУДЛААЧ, СОНГОГЧ ИРГЭН

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Тухай намын зарлагын хэдэн хувь нь и-баримтад бүртгэгдсэн эсэх	Сонгуулийн зардал и-баримтад бүртгэгдэж байгаа байдал, татвар төлсөн эсэх
Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшдэг компани байгаа эсэх	Тусгай зөвшөөрөл эзэмшдэг компанийн хувь хэмжээг мэдэх
Хандивлагчаас компанийн сүүлийн 5 жилийн хугацаанд төрийн худалдан авалтын ажиллагаанд оролцож байсан эсэх	Улс төрийн нам эвсэл шийдвэр гаргагчтай ирээдүйд ашиг сонирхол үүсэж болох эсэх
Эмэгтэй эсвэл тусгай хэрэгцээт нэр дэвшигчдэд намаас гаргасан зарцуулсан	Тэгш оролцоог УТ нам хангаж байгаа эсэхийг мэдэх

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Нийт цугларсан хандив+Улсын төсвөөс хуваарилсан зардал=зарцуулалттай таарч байгаа эсэх (ТАН)	Бэлэн мөнгө тараасан эсэхийг мэдэх
Хандив өгсөн огноогоор харах	Сонгуулийн дараа дүн шинжилгээ хийх
Зарцуулалт: Тойрог, нэр дэвшигч	Сонгуулийн өмнө сонгогчийн боловсролд тустай
Мэдээллийг инфографик хэлбэр, нээлттэй өгөгдөл хэлбэрээр харах, хайх	Мэдээлэлтэй байх, ашиглах, эх сурвалж дурдах, мэдээлэлтэй байх
Нэр дэвшигчийн намд оруулсан хандив	Сонгуулийн өмнө Шийдвэр гаргах
Тойрог бүрийн хандив, нэр дэвшигч хэрэгцээнд ү.а төрлөөр	Сонгуулийн өмнө Шийдвэр гаргах
Хандивлагч нарын нам, хүйс харах	Сонгуулийн өмнө, дараа Хандивлагчийн нас сонголт хийсэн иргэдийн настай хир холбоотойг харах

СЭТГҮҮЛЧИД

Асуудал	Тайлбар /Үндэслэл
Хуулийн этгээдийн хандивын хэмжээ, нэрс	ХОМ, тендер гэх мэт бүртгэлтэй холбож, ашиг сонирхлын зөрчлийг шалгах
Намын нийт/санхүүг мэдээлэх	Мэдээ бэлдэх үед бэлэн байх
Төрийн санхүүжилт зарлах, авах, зарцуулах, тайлагнах, excel, инфографик	Мэдээ бэлдэх үед тулгах

ДҮГНЭЛТ

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 07 сарын 07-нд баталсан билээ. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь улс төрийн намыг бодлогын институт болгон төлөвшүүлэх, дотоод ардчиллыг дэмжиж бэхжүүлэх, намын санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэхэд үзэл баримтлалын хүрээнд батлагдсан. Хуульд туссан намын санхүүгийн ил тод байдлыг хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих нарийвчилсан зохицуулалтын

хэрэгжилтийг бүрэн хангахад намын хандивын бүртгэлийг цахимжуулж, нээлттэй өгөгдлийн сан ашиглах, санхүүгийн тайлан хүлээн авах, хянах, тайлагнах үйл ажиллагаа нийтэд ил тод, хялбар дөхөм байх, үүнд зориулсан цахим систем, программ хангамжийг хөгжүүлэх нь нэн чухал байгааг семинарт оролцсон улс төрийн намууд, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар гэх мэт төрийн байгууллагуудын төлөөлөл болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагууд, судлаачид санал нэгтэй илэрхийлсэн.

ЧУХАЛ СЭДВИЙГ БОЛОВСРУУЛСАН:

Нээлттэй Нийгэм Форумын засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг
СЕХ-ны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаа



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240,
Сүхбаатар дүүрэг, Жамьян гүний гудамж-5/1
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn